

ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР "ТӨААТҮГ"



## **ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН-2018 ОН**

Улаанбаатар хот 2018 он

ЗАСГИЙН  
НИЙТЛЭГ  
ГАЗАР  
ЗАХИРАЛ

БАТЛАВ:  
ГАЗРЫН

БАЙРУУДЫН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТӨААТҮГ-ЫН  
Б.УНДРАМ



## ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

### 1. Үндэслэл

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын журамын 2.1, 2.2, 3.1 тус тус үндэслэв.

### 2. Зорилго

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын санхүүгийн тайланд шинжилгээ хийн, ирээдүйн санхүүгийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүжилтыг үнэлж тодорхойлоход оршино.

### 3. Санхүүгийн шинжилгээгээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

1. Санхүүгийн тайлангийн бүтцийн шинжилгээ хийж тайлангийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг судлах замаар үйл ажиллагааны хандлага, асуудлыг шинжилж тогтоох.
2. Зэрэгцүүлсэн шинжилгээг хийж байгууллагын үйл ажиллагааны үр дүн эдийн засгийн потенциалыг харуулах.
3. Харьцааны шинжилгээгээр байгууллагын өнгөрсөн ба өнөө үеийн хөрвөх чадварын түвшинг харьцуулан шинжлэх.
4. Ашигт ажиллагааны шинжилгээг олон талаас нь шинжилж ашиг орлого, нийт хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө зэргийг харьцуулан ашигт ажиллагааны дүнг тодорхойлох

### 4. Хамрах хүрээ

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын санхүү бүртгэлийн хэлтэс хамрагдана.

## **5. Шалгуур**

Санхүүгийн шинжилгээ зорилго, зорилттой холбогдуулан дараах хууль, дүрэм, журам, арга аргачлыг шалгуур болгоно. Үүнд:

1. Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын дотоод хяналт шалгалтын дүрэм, журам
1. Санхүүгийн шинжилгээ хийх арга, аргачлал
2. Шинжилгээний Du Pont загвар
3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
4. Бусад холбогдох бусад хууль тогтоомж, заавар журмууд

## **6. Хугацаа**

Санхүүгийн шинжилгээг 2018 оны 08 дугаар сарын 08 -ны өдрөөс 08 дугаар сарын 16-ны хооронд ажлын 7 өдөр хийж холбогдох албан тушаалтанд танилцуулна.

## **7. Шинжилгээ, үнэлгээний тайланг нэгтгэн гаргах**

Шинжилгээний тайланг удирдамжинд заасан хугацаанд бэлэн болгож ажлын 7 хоногийн дотор байгууллагын захиралд танилцуулах.

Удирдамж боловсруулсан:  
Дотоод аудит, хяналт үнэлгээ  
хариуцсан мэргэжилтэн:



Г.Бямбацогт

ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

# Санхүүгийн шинжилгээ



Улаанбаатар хот  
2018 он

**Нэг. Санхүүгийн тайлангийн шинжилгээ**

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын 2015, 2016, 2017 онууд болон 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд санхүүгийн шинжилгээг хийж гүйцэтгэн, байгууллагын санхүүгийн өнөөгийн хүрсэн түвшин, ирээдүйн төлөв байдлыг тодорхойлж, байгууллагын эдийн засгийн үзүүлэлтүүдийг хооронд нь харьцуулах боломжийг ханган ажиллахыг зорилоо.

**Consolidated Statements of Financial Position- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан.**

Хүснэгт-1

Үзүүлэлт	2016	2017	2018 /хагас жил/
<b>Revenue</b>	3,458,896,249.49	4,801,041,745.30	2,632,684,417.33
<b>Cost of sales</b>	3,597,861,586.61	4,903,903,342.89	2,712,101,227.14
<b>Gross profit - Нийт ашиг</b>	(138,965,337.12)	(102,861,597.59)	(79,416,809.81)
<b>Selling, general and administrative expenses- ерөнхий болон захиргааны зардал</b>			
<b>Operating profit-Үйл ажиллагааны ашиг</b>			
<b>Other non-operating income- Бусад үйл ажиллагааны орлого</b>	45,383,749.04	1,050,000.00	9,322,739.33
<b>Other non-operating expense- Бусад ү.а.ны зардал</b>	391,402,421.12	675,641,841.88	267,996,734.64
<b>After income tax expense- татварын дараах зардал</b>			
<b>Profit before income tax- Орлогын албан татварын өмнөх ашиг</b>			
<b>Profit for the year - Жилийн ашиг</b>	(158,820,533.79)	(103,037,437.74)	(79,416,809.81)

**Consolidated Statements of Financial - Position Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан**

Хүснэгт-2

Үзүүлэлт	2016	2017	2018 /Хагас жил/
<b>Current Assets- Эргэлтийн хөрөнгө</b>	533,767,684.5	861,208,860.2	869,534,220.18
<b>Non-current assets- Эргэлтийн бус хөрөнгө</b>	3,947,727,349.2	5,335,733,818.0	5,259,265,208.24
<b>Total assets - Нийт актив</b>	4,481,495,033.7	6,196,942,678.2	6,128,799,428.42
<b>Current liabilities - Эргэлтийн өр төлбөр</b>	46,266,251.0	10,834,085.3	22,107,645.30
<b>Non-current liabilities - Эргэлтийн бус өр төлбөр</b>	-	-	-
<b>Total liabilities - Нийт өр төлбөр</b>	46,266,251.0	10,834,085.3	22,107,645.30
<b>Retained earnings - Хуримтлагдсан ашиг</b>	-1,749,592,276.8	-1,852,629,714.5	1,932,046,524.30
<b>Total equity - Нийт өөрийн хөрөнгө</b>	4,435,228,782.7	6,186,108,592.9	4,174,645,258.82
<b>Total liabilities and equity - Нийт пассив ба з.өмч</b>	4,481,495,033.7	6,196,942,678.2	4,196,752,904.12

### 1.1. Бүтцийн шинжилгээ

Энэхүү шинжилгээгээр тайлангийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг судлах замаар үйл ажиллагааны хандлага, асуудлыг шинжилж тогтоох зорилготой хийж гүйцэтгэлээ. Санхүүгийн тайлангийн бүтцийн шинжилгээг хэд хэдэн хэлбэрээр, абсолют үзүүлэлтүүдийн харьцангуй өсөлтийн хурдыг тооцоолох замаар суурь үзүүлэлтээс дараагийн хэд хэдэн жилд өссөн өсөлтийн хурдыг харуулж мөн зөвхөн үзүүлэлт тус бүрийн өөрчлөлтийг харуулаад зогсохгүй үзүүлэлтүүдийн цаашдын динамик өөрчлөлтийг урьдчилан тооцоолох боломж олгодог.

2017 он	Дүнд Эзлэх %	2016 он	Дүнд эзлэх хувь	Өөрчлөлт Абсолют	Харьцангуй
---------	--------------------	---------	-----------------------	---------------------	------------

<b>Current Assets</b> Эргэлтийн хөрөнгө	861,208,860.2	14%	533,767,684.5	12%	327,441,175.7	5.3%
<b>Non-current assets</b> Эргэлтийн бус хөрөнгө	5,335,733,818.0	86%	3,947,727,349.2	88%	1,388,006,468.8	22.4%
<b>Total assets</b> Нийт актив	6,196,942,678.2	100%	4,481,495,033.7	100%	1,715,447,644.5	28%
<b>Current liabilities</b> Эргэлтийн өр төлбөр	10,834,085.3	100%	46,266,251.0	100%	(35,432,165.7)	
<b>Non-current liabilities</b> Эргэлтийн бус өр төлбөр	-		-		-	
<b>Total liabilities</b> Нийт өр төлбөр	10,834,085.3	100%	46,266,251.0	100%	(35,432,165.7)	
<b>Retained earnings</b> Хуримтлагдсан ашиг	(1,852,629,714.5)		(1,749,592,276.8)		(103,037,437.7)	
<b>Total equity</b> Нийт өөрийн хөрөнгө	6,186,108,592.9	99%	4,435,228,782.7	98%	1,750,879,810.2	28%
<b>Total liabilities and equity</b> Нийт пассив ба э.өмч	6,196,942,678.2	100%	4,481,495,033.7	100%	1,715,447,644.5	28%

Балансын бүтцийг хөрөнгийн бүтцээр нь авч үзвэл: Нийт эргэлтийн хөрөнгө 2017 онд өмнөх оноос 327,441,175.7 сая төгрөгөөр нэмэгдэж 5.3% -иар өссөн үзүүлэлттэй байна. Мөн 2018 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оноос 8,325,359.98 төгрөгөөр нэмэгдсэн байна. Эзний өмч 2016 оны гүйцэтгэлээр нийт хөрөнгийн 98%-ийг эзэлж байсан бол 2017 онд 99% болж өмнөх оноос 1%-иар өсөж, харин өр төлбөрийн эзлэх хувийн жин 2016 онд 46,266,251.0 сая төгрөгийг эзэлж байсан бол 2017 онд 10,834,085.3 сая төгрөг болон буурсан байна. Үүнийг дагаад хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 1,715,447,644.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Эргэлтийн хөрөнгийн хэмжээ нийт хөрөнгийн хэмжээтэй харьцуулахад буурсан дүн ажиглагдаж байгаа боловч байгууллагын өөрийн эргэлтийн хөрөнгөө эргэлтийн бус хөрөнгө рүү шилжүүлэх замаар нийт активийн хэмжээгээ нэмэгдүүлсэн байна. Үүнд:

Бараа материал, хангамжийн материалуудад шилжүүлэх замаар хөрөнгө нэмэгдсэн байна.

Хуримтлагдсан үр дүн жил ирэх тусам сөрөг тэмдэгтэй өсөж, нийт ашиг сөрөг утгатай байгаа нь байгууллагын үйл ажиллагаа алдагдалтай ажиллаж байгааг харуулж байна.

### **1.2. Зэрэгцүүлсэн шинжилгээ.**

Зэрэгцүүлсэн шинжилгээг явуулж байгаа зорилгоос нь хамааруулан хоёр ангилж үздэг.

1. Ашиглагдаж байгаа нөөц болон бусад хүчин зүйлийн хэмжээний үзүүлэлтүүдээрээ ялгаатай. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн, аж ахуй хоорондын эдийн засгийн потенциалыг харьцуулах.

Санхүүгийн тайлангийн абсолют үзүүлэлтүүдийг гажуудуулах ялангуяа түүний динамик өсөлтийг нь харьцуулахад төвөгтэй болгодог. Инфляцийн сөрөг нөлөөллийг тодорхой түвшинд багасгах зэрэг болно.

	2018 /Эхний хагас жил/	2017	2016	2015	Өөрчлөлтүүд		Харьцангуй %	
Current Assets- Эргэлтийн хөрөнгө	869,534,220.18	861,208,860.2	533,767,684.5	403,242,666	327,441,175.7	130,525,018.5	38%	24.4%
Non-current assets Эргэлтийн бүсхөрөнгө	5,259,265,208.24	5,335,733,818.0	3,947,727,349.2	4,114,199,476	1,388,006,468.8	(166,472,126.8)	26%	
Total assets Нийт актив	6,128,799,428.42	6,196,942,678.2	4,481,495,033.7	4,517,442,142	1,715,447,644.5	(35,947,108.3)	28%	
Current liabilities Эргэлтийн өр төлбөр	22,107,645.30	10,834,085.3	46,266,251.0	6,493,897	35,432,165.7	39,826,354		86%
Non-current liabilities Эргэлтийн бус өр төлбөр	-	-	-	-	-	-	-	-
Total liabilities Нийт өр төлбөр	22,107,645.30	10,834,085.3	46,266,251.0	6,493,897	(35,432,165.7)	39,772,354		89%
Retained earnings Хуримтлагдсан ашиг	1,932,046,524.30	1,852,629,714.5	1,749,592,276.8	-2,053,150,796				
Total equity Нийт өөрийн хөрөнгө	4,174,645,258.82	6,186,108,592.9	4,435,228,782.7	4,510,948,245				
Total liabilities and equity Нийт пассив ба э.өмч	4,196,752,904.12	6,196,942,678.2	4,481,495,033.7	4,517,442,142	1,715,447,644.5	(35,947,108.3)	28%	

### 1.3 Харьцааны шинжилгээ

#### 1. Хөрвөх чадварын шинжилгээ

Байгууллагын санхүүгийн хөрвөх чадвар нь богино хугацаат өр төлбөрөө аль хэр хурдан төлж барагдуулах чадвараар тодорхойлогдоно. Хөрвөх чадвар бол компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварын хэмжүүр болно. Байгууллагын хөрвөх чадварыг хэмждэг 3 гол харьцаа байдаг. Үүнд:

1. Ажлын цэвэр капитал
2. Эргэлтийн харьцаа
3. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа Үүнд:

#### 1. Ажлын цэвэр капитал (АЦК) *W*

Ажлын цэвэр капиталыг тооцохдоо нийт эргэлтийн хөрөнгийн дүнгээс нийт эргэлтийн эх үүсвэрийн дүнг хасна.

ЗГБНҮГ-ын АЦК нь:


$$АЦК_{2018} = 869,534,220.18 - 22,107,645.30 = 847,426,574.88 \text{ /эхний хагас жилээр/}$$

$$АЦК_{2017} = 861,208,860.2 - 10,834,085.3 = 850,374,774.9$$

$$АЦК_{2016} = 533,767,684.5 - 46,266,251.0 = 487,501,433.5$$

$$АЦК_{2015} = 403,242,666 - 6,493,897 = 396,748,769$$

Ажлын цэвэр капитал нь компанийн хөрвөх чадварын нэг чухал үзүүлэлт болдог. Мөнгөн дүнгээр илэрхийлэгддэг учир энэ үзүүлэлтийг бусад компанийн үзүүлэлттэй харьцуулахад өөрөөр хэлбэл салбарын харьцуулсан шинжилгээнд ашиглахад тохиромжтой биш. Харин компанийн өнгөрсөн ба өнөө үеийн хөрвөх чадварын түвшинг харьцуулан шинжлэхэд чухал ач холбогдолтой үзүүлэлт болно.



Зураг.1 Ажлын цэвэр капитал

Ажлын цэвэр капитал бол компанийн санхүүгийн байдалд, төлбөрийн чадварын хэмжүүр болдог ба манай байгууллагын хувьд энэ үзүүлэлт сайн бөгөөд жил бүр өсч байгааг харуулж байна. 2018 оны гүйцэтгэлээр нийт хөрөнгийн дүн нэмэгдэх чиг хандлагатай байна.

### 1.3. Эргэлтийн харьцаа (ЭХ)

Эргэлтийн харьцаа нь богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөө ашиглан төлөх чадвар ямар байгааг илэрхийлнэ.

$$ЭХ_{2015} = \frac{403,242,666}{6,493,897} = 6,2$$

$$ЭХ_{2016} = \frac{533,767,684.5}{46,266,251.0} = 11,5$$

$$ЭХ_{2017} = \frac{861,208,860.2}{10,834,085.3} = 79$$

$$ЭХ_{2018} = \frac{869,534,220.30}{22,107,645.30} = 39 \text{ /эхний хагас жилээр/}$$

АЦК-г эргэлтийн хөрөнгөнд харьцуулсан харьцаатай тэнцүү. Богино хугацаат эх үүсвэрийг төлөх эх үүсвэр нь эргэлтийн хөрөнгө гэж үзэх юм бол богино хугацаат өр

төлбөрөө 100% төлөх чадвартай үлдээд, эргэлтийн хөрөнгөө бууруулж болох хэмжээг харуулж байна.  $1.09 = 1.47$

$$2015 \text{ он } \left(1 - \frac{1}{6.2}\right) \times 100\% = 16.1\%$$

$$2016 \text{ он } \left(1 - \frac{1}{11.5}\right) \times 100\% = 8.6\%$$

$$2017 \text{ он } \left(1 - \frac{1}{79}\right) \times 100\% = 1.3\%$$

$$2018 \text{ он /эхний хагас жил/ } \left(1 - \frac{1}{39}\right) \times 100\% = 2.6\%$$



Эргэлтийн харьцаа 1-тэй тэнцүү үед АЦК=0 байна. ЭХ<1 үед АЦК сөрөг тэмдэгтэй болно. ЭХ нь салбарын болоод хугацааны харьцуулсан шинжилгээний аль алинд нь ашигладаг. Эргэлтийн харьцаа хоёртой тэнцүү байх нь хамгийн тохиромжтой гэж үздэг боловч энэ нь салбар болон компанийн онцлогоос шалтгаална. Манай байгууллагын хувьд эргэлтийн харьцаа 2017, 2018 оны эхний хагас жилд таатай байгаа бөгөөд тохиромжтой байна. Энэ нь байгууллагын ирээдүйн мөнгөн урсгалыг урьдчилан таамаглах боломж их байх тусам эргэлтийн харьцаа бага байх боломжтой байна.


## 2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (ТТГЧ)

$$ТТГЧ_{2015} = \frac{403,242,666 - 394,662,113.63}{6,493,897} = 1.3$$

$$TTГЧ_{2016} = \frac{533,767,684.5 - 363,266,251.0}{46,266,251.0} = 3,7$$

$$TTГЧ_{2017} = \frac{861,208,860.2 - 435,582,722.6}{10,834,085.3} = 40$$

$$TTГЧ_{2018} = \frac{869,534,220.18 - 438,644,882.98}{22,107,645.30} = 19 \text{ /эхний хагас жилээр/}$$



Зураг.3. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 1-ээс их байх нь тохиромжтой байдаг тул манай байгууллагын хувьд 2017 онд илүү тохиромжтой ажилласан гэж үзэж байгаа бөгөөд цаашдаа энэ үзүүлэлтээ улам тогтвортой байлгахын тулд ажиллаж байна. ТТГЧ өндөр байх нь манай байгууллагын хөрвөх чадвар сайн байх болно.

#### 1.4. Үйл ажиллагааны шинжилгээ

Үйл ажиллагааны харьцаанууд нь компанид янз бүрийн хэлбэрээр байршсан хөрөнгө ба эх үүсвэрүүдийн борлогдох, эсвэл мөнгө болж орж ирэх хурдыг илэрхийлнэ. Хөрвөх чадварын харьцаанууд компанийн хөрвөх чадварыг ерөнхийд нь тодорхойлдог бол үйл ажиллагааны харьцаанууд нь тодорхой данснуудын хөрвөх чадварыг илэрхийлдэг гэж үзэж болно.

## 1.5. Бараа материалын эргэлт (БМЭ)

Бараа материалын эргэлтийн харьцаа нь бараа материалын нөөцийн хөрвөх чадварыг илэрхийлнэ.


## 1.6 Үндсэн хөрөнгийн эргэлт

$$VXЭ_{2015} = \frac{3,108,758,068.50}{4,103,709,550.01} = 0.75 \text{ удаа}$$

$$VXЭ_{2016} = \frac{3,458,896,249.49}{3,940,347,984.00} = 0.8 \text{ удаа}$$

$$VXЭ_{2017} = \frac{(4,801,041,745.30)}{5,335,733,818.0} = 0.89 \text{ удаа}$$

$$VXЭ_{2018} = \frac{2,632,684,417.33}{5,142,444,764.33} = 0.51 \text{ удаа}$$



Зураг.3. Үндсэн хөрөнгийн эргэц

Үндсэн хөрөнгийн эргэц өндөр байх тусам хөрөнгөө үр ашигтай ашиглаж байгааг илтгэдэг тул манай байгууллагын хувьд хөрөнгөө төдийлөн үр ашигтай ашиглаж чадахгүй байгааг харуулж байна. Энэ нь барилга байгууламжийн чанар, түүнд зарцуулагдаж байгаа урсгал засвар, сул чөлөөтэй байгаа өрөө тасалгааг түрээслэх зэргээс хамаарна.

### 1.7 Нийт хөрөнгийн эргэц

Энэ харьцаа нь компанийн нийт хөрөнгийн үр ашгийг илэрхийлнэ. Нийт хөрөнгийн эргэлт өндөр байх нь хөрөнгийн үр ашиг өндөр байгааг илэрхийлнэ.

**НХЭ = Борлуулалт/Нийт хөрөнгө**

$$НХЭ_{2015} = \frac{3,108,758,068.50}{4,517,442,141.97} = 0.68 \text{ удаа}$$

$$НХЭ_{2016} = \frac{3,458,896,249.49}{4,481,495,033.7} = 0.77 \text{ удаа}$$

$$НХЭ_{2017} = \frac{4,801,041,745.30}{6,196,942,678.2} = 0.77 \text{ удаа}$$

$$НХЭ_{2018} = \frac{2,632,684,417.33}{6,128,799,428.42} = 0.42 \text{ удаа}$$



Нийт хөрөнгийн эргэц бага байгаа нь борлуулалтын орлого бага байгааг харуулж байна. Манай байгууллагын хувьд орлогын эх үүсвэр нь нийтлэг үйлчилгээ үзүүлдэг засгийн газрын байрууд юм. Орлогыг нэмэгдүүлэхийн тулд барилга байгууламжийн өрөө тасалгааг 100% ашиглаж, түрээслэж, нийтлэг үйлчилгээг нэмэгдүүлэх.

### 1.8 Өрийн харьцаа


Өрийн харьцаа нь нийт эх үүсвэр дотор зээлийн эх үүсвэрийн эзлэх хувь буюу нийт хөрөнгийн дотор зээлийн эх үүсвэрээр санхүүжигдэж байгаа хэсгийн хувь хэмжээг илэрхийлнэ.

$$OX_{2015} = \frac{6,493,897.00}{4,517,442,141.97} = 0.0014 = 0.14\%$$

$$OX_{2016} = \frac{46,266,251.0}{4,481,495,033.7} = 0.0103 = 1.03\%$$

$$OX_{2017} = \frac{10,834,085.3}{6,196,942,678.2} = 0.0017 = 0.17\%$$

$$OX_{2018} = \frac{22,107,645.30}{6,128,799,428.42} = 0.0036 = 0.36\%$$



Өрийн харьцаа бага гарах тусам ашигтай. ЗГБНҮГазар нь 2016-2017 онуудад өрийн харьцаа нэмэгдэж, 2016 онд өр төлбөр 46,266,251.0 төгрөг болж, 2017 онд 10,834,085.3 төгрөг болон буурч мөн нийт хөрөнгийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна. Энэ үзүүлэлтүүд нь манай байгууллага өрийн хэмжээгээ богино хугацаанд төлөх чадвартайг харуулж байна.

### 1.9 Ашигт ажиллагааны шинжилгээ

Ашигт ажиллагааг олон талаас нь шинжилж үздэг. Тухайлбал ашиг орлогыг борлуулалт, нийт хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцааны үнэд харьцуулан ашигт ажиллагааны дүнг тодорхойлж болно

### 1.9.1 Хувиар илэрхийлсэн орлогын тайлан

Ашигт ажиллагааны шинжилгээнд түгээмэл хэрэглэгддэг нэг хэлбэр нь орлогын тайлангийн үзүүлэлтийг борлуулалтанд эзлэх хувиар илэрхийлэн тооцож хувиар илэрхийлсэн орлогын тайлангийн өнгөрсөн ба өнөөгийн үзүүлэлтийг компаний хооронд харьцуулахад маш тохиромжтой байдаг.

### 1.9.2 Нийт ахиуц ашиг

Нийт ахиуц ашиг борлуулсан бүтээгдэхүүний өртгийг төлөөд борлуулалтаас үлдэж буй орлогын хэмжээг харуулна. Ахиуц ашиг өндөр байвал борлуулсан бүтээгдэхүүний өртөг бага байна. Ахиуц нийт ашиг нь бага байвал борлуулсан бүтээгдэхүүний өртөг өндөр байна. Манай байгууллагын хувьд 2015-2017 он хүртэл санхүүгийн тайланд үйл ажиллагааны орлогоос үйл ажиллагааны зардлын дүн илүү байгаа нь нийт ахиуц ашиг сөрөг утгатай байна.

### Санал, зөвлөмж

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын 2015, 2016, 2017 онууд болон 2018 оны эхний хагас жил хүртэлх санхүү байдлын тайланд шинжилгээг хийхэд тус онуудад үйл ажиллагааны орлогоос үйл ажиллагааны зардлын дүн хэтрэлттэй байгаа тул манай байгууллага алдагдалтай ажиллаж байгааг харуулж байна. Нийт зардалд байр ашиглалттай холбоотой зардал, бараа үйлчилгээ, эд хогшил, урсгал засварын зардлууд ихэнх хувийг эзэлж байна. Засгийн газрын байруудын ихэнх нь хуучин барилгууд учир урсгал засварын зардал их байна. ~~Байгууллагын биет хөрөнгийн барилга, байгууламж~~

Түрээсийн гэрээгээр хамтран ажиллаж буй байгууллагуудтай түрээсийн төлбөрийг үндсэн хөрөнгөөр бус мөнгөөр хүлээн авч түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх.

Гэрээт байгууллагатай гэрээ байгуулахдаа ажил үйлчилгээний нийт зардлыг байгууллага тус бүрт нарийн тооцоолж гэрээ байгуулах.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос гадна бусад орлогын хэмжээг шат дараалалтайгаар нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлж, эргэлтийн хөрөнгийн дүнг өсгөж, жилээр баталсан орлогын хэмжээг гүйцэтгэлээр бүрэн гүйцэд ханган ажиллах.

Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөний зардлын төсвийг батлуулахад эдийн засаг, цаг үеийн нөхцөл байдал болон инфляцитай уялдуулж төсөв хөрөнгөд тусгаж батлуулах.

Авлагыг цаг тухай бүрт аван ханган ажиллаж эргэлтийн хөрөнгийн дүнг нэмэгдүүлэн төсвийн тухай хуулийн дагуу ажиллах. 2018 оны эхний хагас жилийн байдлаар үйл ажиллагааны байдлаар 2,632,684,417.33 мян төгрөг үйл ажиллагааны нийт зардал 2,712,101,227.14 мян төгрөг, алдагдал 79,416,809.01 мян төгрөг байна. 2018 оны эцсийн байдлаар гүйцэтгэлээр 150 орчим сая төгрөгний алдагдалтай ажиллах үр дагавар гарч болзошгүй байна.

Уаншиг ташингав.  
Идгэе. 2018.09.07